

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗЦГ	Замын цагдаагийн газар

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД ТАНАА

2020.02.21 № 06/550
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, батлагдсан төсвийн дагуу зардал гаргах, хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэх зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт аудитор Б.Мөнгөнцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03/292 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал юм.

Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын хөгжлийг дэмжсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, оновчтой хуваарилах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төсөв төлөвлөх, хэрэгжүүлэх, салбарын стандарт, норматив, техник, технологийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Авто тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;
- Иргэний нисэхийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах;
- Зам тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ, дотоод аудит хийх, захиргааны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан,
- Тээврийн хэрэгслийн гэрчилгээний орлогыг Зам, тээврийн хөгжлийн яамны санхүүгийн тайланд тусгасан,
- Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг баримтлан ажилласан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Зам, тээврийн хөгжлийн яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 7,803,926.9 мянган төгрөгөөс тооцон 156,078.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн болох 8,953,161.7 мянган төгрөгөөс 2.0 хувиар тооцон материаллаг байдлын түвшинг 179,063.2 мянган төгрөгөөр тооцсон нь тайлант оны суурь үзүүлэлтийн дүнг авч үзсэнтэй холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,923,633.7 мянган төгрөгөөр буюу 21.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,469,046.3	5,147,025.6	677,979.3
Авлага	842.4	0.0	(842.4)
Бараа материал	57,036.8	79,580.3	22,543.4
Үндсэн хөрөнгө	2,596,624.2	3,820,577.5	1,223,953.3
Нийт хөрөнгө	7,123,549.7	9,047,183.4	1,923,633.7
Өр төлбөр	4,226.7	0.0	(4,226.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,119,323.0	9,047,183.4	1,927,860.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,123,549.7	9,047,183.4	1,923,633.7

Авлага дансны үлдэгдэл буурсан нь НДШ-ийн авлагыг 842.4 мянган төгрөгийн барагдуулснаар тайлант хугацааны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22,543.4 мянган төгрөгөөр өссөн нь Тээврийн хэрэгслийн гэрчилгээний маягтыг 171,325.0 мянган төгрөгөөр худалдан авснаас шалтгаалжээ.

Энэ нь Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т¹ заасны дагуу шаардлагатай авто тээврийн хэрэгсэлийн бүртгэлийн маягтыг худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Авто тээврийн хэрэгсэл 198,000.0 мянган төгрөг, тоног, төхөөрөмж 61,639.0 мянган төгрөгөөр, тавилга, аж ахуйн эд хогшил 9,311.1 мянга, биет бус хөрөнгө 1,174,588.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

ТӨБЗГ-ын 2019 оны 83 дугаар тушаалаар ИНЕГ-аас 198,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 2019 оны 128 дугаар тушаалаар 50,283.0 мянган төгрөгийн тоног, төхөөрөмжийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авснаар нийт 248,283.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 495 дугаар тогтоолоор 19,300.0 мянган төгрөгийн автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгосон, ТӨБЗГ-ын 2019 оны А-1/3953 дугаар албан тоотыг үндэслэн 23,250.2 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хасах зөвшөөрөл олгосныг тус тус үндэслэн нийт 42,550.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс, бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь Нийслэлийн ЗД-ын 2019 оны А/45 дугаар шийдвэрээр Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны 19.9 м.кв га газрыг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг үндэслэн 1,174,588.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь цалингийн өглөгийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,047,183.5 мянган төгрөг болж 1,927,860.4 мянган төгрөгөөр өссөн нь засгийн газрын оруулсан капитал данс 1,174,588.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн данс 753,271.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь биет бус хөрөнгө 1,174,588.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотойгоор засгийн газрын оруулсан капитал данс нэмэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 3,485,730.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,452,719.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,452,719.9 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардлыг 16.0 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 63.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 186.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

¹ Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-д¹ “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулах” гэж заасан байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 2,852,742.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнд:

Засгийн газрын 2019 оны 236 дугаар тогтоолоор 1,395,457.4 мянга, Сангийн сайдын 2019 оны 251 дүгээр тушаалаар 1,457,285.5 мянга нийт 2,852,742.9 мянган төгрөг олгосноос 2,839,425.8 зарцуулж, үлдэгдэл 13,317.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 33,010.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн зарцуулалтаас хэмнэгдсэн 13,317.1 мянган төгрөг, Улсын комисс хүлээн авсан 1,425,961.9 мянган төгрөгийн автозамын барилгын ажлын техник хяналтын зардлыг, Авто тээврийн үндэсний төвөөс тээврийн хэрэгслийн гэрчилгээг борлуулсны орлого болох 178,979.4 мянган төгрөг, нийт 1,651,268.8 мянган төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 17 эрсдэл тодорхойлж нийт 42 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4,293,661.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,282,469.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,192.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн яамны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 95 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,667.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,466.9 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас төлсөн, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлаас 6,475.0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллыг тус тус баримтлан ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

ТНБД-ын өмнөх оны тушаалаар томилолтын зардал болон буцалтгүй тусламжид 2,250.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтгүй зарлага гарснаар үр ашиггүй зардал гарах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид санхүүгийн анхан шатны бүртгэлийг сайжруулж, тайлант хугацаанд гарсан тушаалаар зарлага гаргаж байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

ЗЦГ-аас хүлээн авсан тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний програм болон өгөгдлийн сангийн серверийг санхүүгийн тайланд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д “Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, 6.1.12-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Хөрөнгө бүртгэхгүй байснаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний програм болон өгөгдлийн сангийн серверийг санхүүгийн тайланд үнэлж, бүртгэх арга хэмжээ авах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,526,925,579.26	5,226,605,968.73
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	4,469,046,304.22	5,147,025,625.10
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	0.00
31110	Төгрөг	-	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,469,046,304.22	5,147,025,625.10
3121	Төгрөг	4,469,046,304.22	5,147,025,625.10
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31214	Бусад төсөл нөөцийн харилцах	4,469,046,304.22	5,147,025,625.10
33	АВЛАГА	842,408.81	(0.00)
33402	Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	842,408.81	(0.00)
35	БАРАА МАТЕРИАЛ	57,036,866.23	79,580,343.63
354	Хангамжийн материал	57,036,866.23	79,580,343.63
35410	Бичиг хэргийн материал	26,027,310.00	46,214,682.40
35420	Аж ахуйн материал	11,924,921.00	13,849,714.00
35440	Түлш шатах тослох материал	733,437.00	92,369.00
35470	Бусад хангамжийн материал	18,351,198.23	19,423,578.23
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,596,624,172.03	3,820,577,492.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,596,624,172.03	3,820,577,492.39
392	Биет хөрөнгө	1,768,435,505.33	1,818,376,692.39
39201	Барилга, байгууламж	1,549,894,744.40	1,549,894,744.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(78,782,818.45)	(144,870,902.89)
39203	Авто тээврийн хэрэгсэл	276,458,040.00	398,358,040.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(121,809,695.85)	(131,902,166.83)
39205	Машин, тоног төхөөрөмж	519,367,141.39	577,437,487.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(466,585,611.12)	(501,004,464.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	350,788,102.23	342,803,607.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(261,035,397.27)	(272,480,653.11)
39217	Номын фонд	141,000.00	141,000.00
393	Биет бус хөрөнгө	828,188,666.70	2,002,200,800.00
39301	Програм хангамж	38,532,700.00	38,532,700.00
39302	Хасагдуулга	(37,956,033.30)	(38,532,700.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	827,612,000.00	2,002,200,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,123,549,751.29	9,047,183,461.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4,226,727.35	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,226,727.35	0.00
413	Өглөг	4,226,727.35	0.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	4,226,727.35	0.00
4136	Бусад өглөг	-	(0.00)
41361	Байгууллагад төлөх өглөг	-	(0.00)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	7,119,323,023.94	9,047,183,461.12

51	Засгийн газрын хувь оролцоо	7,119,323,023.94	9,047,183,461.12
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	6,698,689,340.11	7,873,278,140.11
51101	Өмч: -Төрийн өмч	6,698,689,340.11	7,873,278,140.11
512	Хуримтлагдсан үр дүн	174,626,755.94	927,898,393.12
51210	Өмнөх үеийн үр дүн	174,626,755.94	174,626,755.94
51220	Тайлант үеийн үр дүн	-	753,271,637.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	246,006,927.89	246,006,927.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	7,123,549,751.29	9,047,183,461.12

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,803,926,988.73	8,953,161,712.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,775,844,761.73	2,601,371,412.87
120	Нийтлэг татварын бус орлого	1,775,844,761.73	2,601,371,412.87
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,775,836,761.73	2,584,456,674.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	178,879,450.00
1200044	НД хөнгөлөлт	1,604,325.48	-
1200042	Туслах үйл ажиллагаанаас санхүүжсэн орлого	1,751,985,769.25	2,197,526,624.88
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,246,667.00	208,050,599.99
120009	Бусад орлого	8,000.00	16,914,738.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,028,082,227.00	6,351,790,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,221,282,600.00	3,485,730,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,221,282,600.00	3,485,730,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,806,799,627.00	2,866,060,000.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	2,806,799,627.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,866,060,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	6,211,389,445.25	8,182,251,019.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,211,389,445.25	8,182,251,019.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,030,161,318.53	7,860,180,530.62
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,069,081,619.00	2,291,916,686.00
210101	Цалин	2,069,081,619.00	2,291,916,686.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	248,257,072.74	290,659,716.94
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	166,496,496.74	199,388,529.94
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	20,482,609.00	22,817,799.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	16,429,765.00	18,254,237.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	4,077,109.00	4,563,559.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	40,771,093.00	45,635,592.00
2104	Хангамж, бараа материалын зардал	111,715,896.84	80,845,349.77
210401	Бичиг хэргийн материал	31,063,808.00	34,564,850.00
210402	Тээвэр, шатахууны зардал	10,333,472.00	11,945,258.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	18,233,220.69	16,382,015.77
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	20,780,360.12	17,953,226.00
210408	Бараа материал актасны зардал	31,305,036.03	-
2105	Нормативт зардал	2,200,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,200,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,179,500.00	23,223,586.00
210601	Багаж хэрэгсэл	3,852,100.00	2,174,660.00
210604	Урсгал засвар	17,327,400.00	21,048,926.00
2107	Томиллолт, зочны зардал	108,767,131.00	108,833,987.00
210702	Дотоод томилолтын зардал	108,767,131.00	108,833,987.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	514,573,535.84	508,396,151.65

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	263,685,600.00	267,043,090.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	9,544,500.00	7,475,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	1,141,600.00	1,796,556.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	551,800.00	140,104.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	55,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	25,465,735.84	32,888,456.05
210807	Газрын төлбөр	5,366,200.00	723,700.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	208,752,100.00	198,274,245.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,954,386,563.11	4,556,305,053.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,816,212,307.00	4,392,204,955.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	138,174,256.11	164,100,098.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	181,228,126.72	322,070,488.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,814,883.00	96,863,545.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	83,411,523.00	49,146,736.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,403,360.00	47,716,809.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,069,208.72	225,206,943.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,069,208.72	225,206,943.70
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	17,344,035.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,344,035.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	1,592,537,543.48	770,910,693.55
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	17,639,056.37
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	17,639,056.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(17,639,056.37)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	1,592,537,543.48	753,271,637.18

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Данс	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,504,074,211.22	8,745,111,112.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,475,991,984.22	2,393,320,812.88
120	Нийтлэг татварын бус орлого	4,475,991,984.22	2,393,320,812.88
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,475,983,984.22	2,376,406,074.88
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	178,879,450.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,751,985,769.25	2,197,526,624.88
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	2,723,998,214.97	-
120009	Бусад орлого	8,000.00	16,914,738.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,028,082,227.00	6,351,790,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,221,282,600.00	3,485,730,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,221,282,600.00	3,485,730,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,806,799,627.00	2,866,060,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөнөөс	2,806,799,627.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,866,060,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	6,035,027,907.00	8,067,131,792.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,035,027,907.00	8,067,131,792.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,871,135,815.28	7,745,061,303.30
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,070,717,177.93	2,298,610,321.48
210101	Үндсэн цалин	1,289,563,077.93	1,442,885,321.48
210102	Нэмэгдэл	610,544,100.00	685,115,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,610,000.00	170,610,000.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	241,584,499.82	287,350,400.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	241,584,499.82	254,552,553.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	22,988,000.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	9,809,847.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,465,263.69	80,670,879.77
210401	Бичиг хэрэг	35,766,108.00	34,960,568.00
210402	Тээвэр, шатахуун	10,822,240.00	11,304,190.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,233,220.69	16,382,015.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,643,695.00	18,024,106.00
2105	Нормативт зардал	2,200,000.00	2,227,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,200,000.00	2,227,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,282,100.00	46,975,454.00
210601	Багаж техник хэрэгсэл	8,954,700.00	25,926,528.00
210604	Урсгал засвар	17,327,400.00	21,048,926.00
2107	Томилолт, зочны зардал	108,767,131.00	108,833,987.00
210702	Дотоод албан томилолт	108,767,131.00	108,833,987.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	523,907,335.84	528,187,806.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	263,685,600.00	267,043,090.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,544,500.00	7,475,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,141,600.00	1,796,556.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	551,800.00	140,104.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,465,735.84	32,888,456.05
210807	Газрын төлбөр	5,366,200.00	723,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	218,085,900.00	218,065,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,816,212,307.00	4,392,204,955.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,816,212,307.00	4,392,204,955.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,892,091.72	322,070,488.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,814,883.00	96,863,545.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	83,411,523.00	49,146,736.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,403,360.00	47,716,809.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,069,208.72	225,206,943.70
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,069,208.72	225,206,943.70
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,469,046,304.22	677,979,320.88
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,469,046,304.22	677,979,320.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	4,469,046,304.22
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,469,046,304.22	5,147,025,625.10

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	5,871,077,340.11	-	(1,417,910,787.54)	4,453,166,552.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,871,077,340.11	-	(1,417,910,787.54)	4,453,166,552.57
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	827,612,000.00	-	1,592,537,543.48	2,420,149,543.48
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,698,689,340.11	246,006,927.89	174,626,755.94	7,119,323,023.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,698,689,340.11	246,006,927.89	174,626,755.94	7,119,323,023.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,174,588,800.00	-	-	1,174,588,800.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	753,271,637.18	753,271,637.18
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,873,278,140.11	246,006,927.89	927,898,393.12	9,047,183,461.12

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,485,730,300.00	3,452,719,893.30	33,010,406.70	99.05
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,485,730,300.00	3,452,719,893.30	33,010,406.70	99.05
Бараа, үйлчилгээний зардал	3,356,349,600.00	3,355,856,348.30	493,251.70	99.99
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,298,802,900.00	2,298,610,321.48	192,578.52	99.99
Үндсэн цалин	1,443,077,900.00	1,442,885,321.48	192,578.52	99.99
Нэмэгдэл	685,115,000.00	685,115,000.00	-	100.00
Унаа, болон бусад нөхөн олговор	170,610,000.00	170,610,000.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	287,350,400.00	287,350,400.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	195,398,300.00	254,552,553.00	(59,154,253.00)	130.27
Тэтгэмжийн даатгал	22,988,000.00	22,988,000.00	-	100.00
ҮОМШӨ ний даатгал	18,390,400.00	9,809,847.00	8,580,553.00	53.34
Ажилгүйдлийн даатгал	4,597,600.00	-	4,597,600.00	-
Эрүүл мэндийн даатгал	45,976,100.00	-	45,976,100.00	-
Хангамж, бараа материалын зардал	80,686,900.00	80,670,879.77	16,020.23	99.98
Бичиг хэрэг	38,455,000.00	34,960,568.00	3,494,432.00	90.91
Тээвэр (шатахуун)	14,441,200.00	11,304,190.00	3,137,010.00	78.28
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	15,139,200.00	16,382,015.77	(1,242,815.77)	108.21
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	12,651,500.00	18,024,106.00	(5,372,606.00)	142.47
Нормативт зардал	2,227,500.00	2,227,500.00	-	100.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	2,227,500.00	2,227,500.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	47,039,400.00	46,975,454.00	63,946.00	99.86
Багаж, техник, хэрэгсэл	9,962,500.00	25,926,528.00	(15,964,028.00)	260.24
Урсгал засвар	37,076,900.00	21,048,926.00	16,027,974.00	56.77
Томилолт, зочны зардал	108,867,800.00	108,833,987.00	33,813.00	99.97
Дотоод албан томилолт	108,867,800.00	108,833,987.00	33,813.00	99.97
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	528,374,700.00	528,187,806.05	186,893.95	99.96
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	267,137,100.00	267,043,090.00	94,010.00	99.96
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	7,475,000.00	7,475,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	1,812,900.00	1,796,556.00	16,344.00	99.10
Тээврийн хэрэгслийн татвар	144,000.00	140,104.00	3,896.00	97.29
Тээврийн хэрэгслийн оношилгоо	75,200.00	55,000.00	20,200.00	73.14
Мэдээллийн технологийн зардал	32,888,500.00	32,888,456.05	43.95	100.00
Газрын төлбөр	745,000.00	723,700.00	21,300.00	97.14
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	218,097,000.00	218,065,900.00	31,100.00	99.99
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,380,700.00	96,863,545.00	32,517,155.00	74.87

Засгийн газар хоорондын шилжүүлэг	11,280,000.00	-	11,280,000.00	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,280,000.00	-	11,280,000.00	-
Бусад урсгал шилжүүлэг	118,100,700.00	96,863,545.00	21,237,155.00	82.02
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	49,220,700.00	49,146,736.00	73,964.00	99.85
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,880,000.00	47,716,809.00	21,163,191.00	69.28
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,485,730,300.00	3,452,719,893.30	33,010,406.70	99.05
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,485,730,300.00	3,452,719,893.30	33,010,406.70	99.05
Улсын төсвөөс санхүүжих	3,485,730,300.00	3,452,719,893.30	33,010,406.70	99.05
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,866,060,000.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	2,852,742,913.00
Бараа, үйлчилгээний зардал	-	2,852,742,913.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,852,742,913.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,852,742,913.00
Улсын төсөвт төвлөрүүлсэн		13,317,087.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,866,060,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,866,060,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.13	Аудитын нэр:	Зам, тээврийн хөгжлийн яамны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/73/СТА-ТШЗ
---------------	-------------------	---------------------	-----------------------------------------------------------------	---------------------	----------------------------

Шалгагдсан байгууллагын нэр:	Зам, тээврийн хөгжлийн яам	Мянган төгрөг
-------------------------------------	-----------------------------------	----------------------

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5			9	10
1	Зардал	1	Тайлант онд ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,466.9 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас төлсөн, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлаас 6,475.0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан Зардлын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.	8,941.9	Зөвлөмж өгсөн.	2020.02.14		1.Төрийн нарийн бичгийн дарга 2. ХОУХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	1.С.Батболд 2.Ч.Ренчиндамба
2	Зардал	1	ТНБД-ын өмнөх оны тушаалаар томилолтын зардал болон буцалтгүй тусламжид 2,250.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус нийцэхгүй байна.	2,250.5	Зөвлөмж өгсөн.	2020.02.14		1.Төрийн нарийн бичгийн дарга 2. ХОУХ-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч	1.С.Батболд 2.Ч.Ренчиндамба
3	Биет бус хөрөнгө		ЗЦГ-аас хүлээн авсан тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний програм болон өгөгдлийн сангийн серверийг санхүүгийн тайланд бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ", Авто тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д "Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", 6.1.12-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа авто тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.		Зөвлөмж өгсөн.	2020.02.14		1.Төрийн нарийн бичгийн дарга 2.Ерөнхий нягтлан бодогч	1.С.Батболд 2.Г.Алтангэрэл
Нийт дүн				11,192.4					

